

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР



СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн эдийн засаг,
нийгмийн байдал

2017 он
12-р сар

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2013-2017 ОН	2
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР	3
 ТӨСӨВ	4
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	7
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	16
 ЭРҮҮЛ МЭНД	17
 НИЙГМИЙН ДААТГАЛ	19
 АЖ ҮЙЛДВЭР	20
 НИЙТИЙН ТЭЭВЭР	25
 ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТО МАШИН	33
 ХАРИЛЦАА, ХОЛБОО	37
 ХӨДӨӨ АЖ АХУЙ	39
 ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ	42
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	43
 ГЭМТ ХЭРЭГ	48
 ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	50

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн XII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017
Шинээр төрсөн хүүхэд	тоо	36 421 ^{↑9.3}	37 672 ^{↑3.4}	142 790 ^{↑13.6}	36 885 ^{↓13.8}	34 650 ^{↓6.0}
Ажилгүйчүүд, сарын эцэст	мянган хүн	14.1 ^{↑10.2}	15.8 ^{↑12.1}	12.6 ^{↓20.3}	12.0 ^{↓5.2}	7.0 ^{↓41.2}
үүнээс : эмэгтэй	мянган хүн	7.8 ^{↑13.0}	8.8 ^{↑12.8}	6.9 ^{↓21.6}	6.0 ^{↓12.4}	4.0 ^{↓34.6}
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	18 405 ^{↓26.8}	17 610 ^{↓6.0}	39 925 ^{↑126.7}	39 517 ^{↓1.0}	26 808 ^{↓32.2}
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	15 419 ^{↑19.4}	17 144 ^{↑11.2}	17 939 ^{↑4.3}	17 909 ^{↓0.2}	21 947 ^{↑22.5}
Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт	хувь	12.3 ^{↓1.9}	10.7 ^{↓1.6}	1.1 ^{↓9.6}	0.5 ^{↓0.6}	7.2 ^{↑6.7}
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1 659 ^{↑19.2}	1 888 ^{↑13.8}	1 996 ^{↑5.7}	2 490 ^{↑24.7}	2 427 ^{↓2.5}
Нийслэлийн төсвийн орлого	тэрбум төгрөг	774.7 ^{↑59.6}	808.2 ^{↑4.3}	845.5 ^{↑4.6}	869.9 ^{↑2.9}	721.9 ^{↓17.0}
Нийслэлийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	682.2 ^{↑161.5}	772.3 ^{↑13.2}	882.7 ^{↑14.3}	1 021.2 ^{↑15.7}	1 075.3 ^{↑5.3}

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан ^{↑, ↓} эерэг өөрчлөлтийн хувь;
^{↑, ↓} сөрөг өөрчлөлтийн хувь;
 = тогтвортой

¹ 2015 онд төрөлтийн тоог Эрүүл мэндийн яамны төрөлтийн бүртгэлээр тооцсон болно.

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2016 оны эцэст				2017 оны эцэст					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	297	Баянгол	7 312	Налайх	53	298	Баянгол	7 416	Налайх	54
			Чингэлтэй	1 812	Багануур	47		Чингэлтэй	1 803	Багануур	47
			Сүхбаатар	667	Багахангай	30		Сүхбаатар	666	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	141	Багахангай	528	Баянзүрх	119	81	Багахангай	489	Сонгинохайрхан	67
			Багануур	326	Баянгол	118		Багануур	196	Хан-Уул	66
			Налайх	322	Сонгинохайрхан	104		Сүхбаатар	135	Чингэлтэй	64
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	15	Багануур	25	Хан-Уул	10	10	Багахангай	28	Хан-Уул	10
			Налайх	22	Баянгол	9		Налайх	16	Чингэлтэй	6
			Баянзүрх	15	Багахангай	0		Багануур	13	Баянгол	6
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	297	Баянзүрх	342	Сонгинохайрхан	238	173	Баянзүрх	220	Налайх	151
			Багануур	287	Хан-Уул	231		Сүхбаатар	170	Багануур	142
			Чингэлтэй	268	Багахангай	70		Чингэлтэй	167	Багахангай	41
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	85	Чингэлтэй	111	Налайх	79	40	Чингэлтэй	90.5	Багануур	9.6
			Хан-Уул	110	Багануур	76		Сүхбаатар	69.8	Налайх	8.1
			Сүхбаатар	109	Багахангай	56		Хан-Уул	42.4	Багахангай	5.7
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	201	Сүхбаатар	320	Багануур	156	238	Сүхбаатар	415	Хан-Уул	182
			Баянгол	226	Сонгинохайрхан	139		Баянзүрх	271	Багануур	132
			Чингэлтэй	225	Багахангай	86		Чингэлтэй	256	Багахангай	114

Тайлбар: * - промилль

** - продицимилль




НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 721.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 10.7 тэрбум төгрөгөөр (1.5%) илүү бүрджээ. Төсвийн нийт орлогын 89.5 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 10.5 хувийг татварын бус орлого эзэлж байна.

2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийслэлийн татварын орлого 646.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 7.5 тэрбум төгрөгөөр (1.2%), татварын бус орлого 75.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 3.2 тэрбум төгрөгөөр (4.5%) тус тус илүү бүрдсэн байна.

Орлогын албан татвар төлөвлөснөөс 3.3 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бол, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 5.8 тэрбум төгрөгөөр, татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 4.9 тэрбум төгрөгөөр тус тус илүү бүрджээ.

Зураг 1. Төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 3. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Төсвийн орлого			Үүнээс:					
	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү	Татварын орлого			Татварын бус орлого		
				Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү
Нийслэлийн дүн	721 966.3	101.5	10 721.1	646 465.7	101.2	7 500.3	75 500.6	104.5	3 220.8
Багануур	1 433.8	122.7	265.2	873.9	128.7	195.1	559.9	114.3	70.1
Багахангай	239.0	125.2	48.2	75.6	111.1	7.5	163.3	133.1	40.6
Баянгол	16 696.6	91.2	-1 617.0	13 429.8	82.9	-2 770.2	3 266.8	154.6	1 153.2
Баянзүрх	19 244.1	93.9	-1 256.0	19 172.1	93.9	-1 255.1	72.0	98.7	-0.9
Налайх	1 406.7	105.7	76.0	1 001.3	94.9	-53.8	405.4	147.1	129.8
Сонгинохайрхан	8 814.5	109.9	794.5	7 426.1	104.3	306.6	1 388.4	154.2	487.9
Сүхбаатар	46 836.7	79.1	-12 344.0	45 548.5	78.2	-12 716.9	1 288.3	140.7	372.9
Хан-Уул	21 903.3	108.2	1 650.7	18 654.0	101.2	218.4	3 249.3	178.8	1 432.3
Чингэлтэй	60 348.0	102.8	1 642.0	58 043.7	104.3	2 366.8	2 304.3	76.1	-724.7
Хотын шууд	545 043.5	104.1	21 461.4	482 240.7	104.6	21 201.8	62 802.8	100.4	259.6

Хүснэгт 4. Нийслэлийн төсвийн орлого, 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая төгрөг
Нийт орлого	711 245.2	721 966.3	101.5	10 721.1
1. Татварын орлого	638 965.4	646 465.7	101.2	7 500.3
Орлогын албан татвар	451 952.3	448 691.2	99.3	-3 261.1
Хувь хүний орлогын албан татвар	451 952.3	448 691.2	99.3	-3 261.1
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	371 328.3	383 204.1	103.2	11 875.8
Үйл ажиллагааны орлогын	21 462.2	27 617.4	128.7	6 155.2
Хөрөнгө борлуулсны орлогын	15 927.2	6 649.8	41.8	-9 277.4
Хувь хүний орлогын татварын буцаан олголт	-25 420.0	-25 415.2	100.0	4.8
Шууд бус орлого	68 654.6	56 635.1	82.5	-12 019.5
Хөрөнгийн албан татвар	72 552.0	78 390.9	108.0	5 838.9
Ул хөдлөх хөрөнгийн албан татвар	47 708.1	53 421.4	112.0	5 713.3
Бууны албан татвар	343.9	368.5	107.1	24.6
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	24 500.0	24 601.0	100.4	101.0
Бусад татвар, төлбөр, хураамж	114 461.1	119 383.6	104.3	4 922.5
Улсын тэмдэгтийн хураамж	56 945.2	59 041.8	103.7	2 096.5
Газрын төлбөр	34 265.6	38 213.7	111.5	3 948.1
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	266.8	138.9	52.1	-127.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	14 271.5	13 510.7	94.7	-760.8
Усны төлбөр	3 677.0	3 336.5	90.7	-340.5
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны	35.0	33.0	94.3	-2.0
Нийслэл хотын албан татвар	5 000.0	4 863.1	97.3	-136.9
Бусад татвар, хураамж	0.0	246.0	-	246.0
2. Татварын бус орлого	72 279.8	75 500.6	104.5	3 220.8
Нийтлэг татварын бус орлого	72 279.8	75 500.6	104.5	3 220.8
Хувьцааны ногдол ашиг	1 100.0	1 103.7	100.3	3.7
Хүүгийн орлого	302.5	3 690.6	1 220.0	3 388.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого	11 095.3	9 847.0	88.7	-1 248.3
Торгуулийн орлого	31 677.7	32 002.3	101.0	324.6
Түрээсийн орлого	1 590.4	1 757.8	110.5	167.4
Бусад нэр заагдаагүй орлого	21 513.9	22 060.6	102.5	546.7
Өмч хувьчлалын орлого	5 000.0	5 038.5	100.8	38.5



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны хэрэглээний үнийн индекс 2016 оны эцэстэй харьцуулахад 7.2 хувиар, өмнөх 11-р сартай харьцуулахад 0.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 4. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2017 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 7.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 3.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 5.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 10.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 5.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 10.7 хувь, тээврийн үйлчилгээ 10.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 4.1 хувь, боловсролын үйлчилгээ 7.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 2.6 хувь, бусад бараа, үйлчилгээний үнэ, тариф 8.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 6. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2015-XII</u> 2014-XII	<u>2016-XII</u> 2015-XII	<u>2017-XII</u> 2016-XII	<u>2017-XII</u> 2017-XI
Ерөнхий индекс	101.1	100.5	107.2	100.3
Хүнсний бараа, ундаа, ус	92.8	101.4	107.9	99.7
Согтууруулах ундаа, тамхи	100.6	104.0	103.9	100.4
Хувцас, бөс бараа, гутал	102.1	98.6	105.1	100.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.1	97.2	110.2	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	105.4	100.8	105.2	100.3
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	104.4	107.8	110.7	102.6
Тээвэр	100.7	99.0	110.5	100.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.3	100.7	99.6	99.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.9	99.2	104.1	100.6
Боловсролын үйлчилгээ	123.6	102.6	107.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	103.5	101.2	102.6	102.5
Бусад бараа, үйлчилгээ	105.8	102.2	108.7	100.5

2017 оны 12-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 22.1 хувийнх нь үнэ өсч, 11.9 хувийнх нь үнэ буурч, 66.0 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 7. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-0.3	Энэ бүлгийн бууралтад талх, гурил, будаа 0.1 хувиар, мах, махан бүтээгдэхүүн 2.9 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.4	Энэ бүлгийн өсөлтөд архи, спирт 0.6 хувиар, дарс 0.5 хувиар, тамхи 0.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Хувцас, бөс бараа, гутал	0.1	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн өсөлтөд хөвөн, бөс бараа 5.6 хувиар, бүх төрлийн хувцас 0.1 хувиар, жижиг эдлэл, хэрэгсэл 0.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.3	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн өсөлтөд гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл 1.9 хувиар, гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан болон бусад бараа 0.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	2.6	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь эм, тариа 4.0 хувиар, шүдний эмнэлгийн үйлчилгээ 3.7 хувиар өссөнтэй холбоотой байна.
Тээвэр	0.7	Тээврийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь автомашин, мотоцикл 2.0 хувиар, тээврийн хэрэгслийн үйлчилгээ 15.0 хувиар тус тус өссөнөөс шалтгаалсан байна.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.4	Энэ бүлгийн бууралтад телефон аппарат, факсын хэрэгсэл 9.6 хувиар буурсан нь нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.6	Энэ бүлгийн өсөлтөд фото зураг, кино зургийн хэрэгсэл, дуран 36.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	2.5	Энэ бүлгийн өсөлтөд гуанз, цайны газрын үйлчилгээ 4.9 хувиар өссөн нь шууд нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.5	Бусад бараа, үйлчилгээний өсөлт нь үсчин болон гоо сайхны үйлчилгээ 2.1 хувиар, хувь хүний бусад эд зүйлс 1.5 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Зураг 5. Нэг кг будааны дундаж үнэ, XII сард, төгрөг




Зураг 6. Нэг кг дээд гурилын дундаж үнэ, XII сард, төгрөг




2017 оны 12-р сард хүнсний зах, дэлгүүрт жижиглэн худалдаалах махны үнэ өмнөх сартай харьцуулахад хонины ястай мах 4.5 хувиар, үхрийн ястай мах 3.1 хувиар тус тус буурсан байна. Өмнөх сартай харьцуулахад талх, гурил, будааны бүлгийн үнэ 0.1 хувиар буурч, харин хүнсний ногооны бүлгийн үнэ 3.2 хувиар өссөн байлаа.


Зураг 7. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, XII сард



Зураг 8. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, XII сард



Зураг 9. Нэг ширхэг өндөгний дундаж үнэ, XII сард



Багануур дүүргийн түүхий эдийн захын дундаж үнээр нас гүйцсэн адуу 450.0 мянган төгрөг, үхэр 750.0 мянган төгрөг, эр хонь 150.0 мянган төгрөг, эм хонь 100.0 мянган төгрөг, ямаа 70.0-80.0 мянган төгрөгийн ханштай байв.


Хүснэгт 8. Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Төрөл	2014		2015		2016		2017	
	XI	XII	XI	XII	XI	XII	XI	XII
	төгрөг							
Тэмээний шир	20 500	21 000	23 500	25 000	17 500	17 500	17 500	21 000
Адууны шир	36 000	39 000	41 333	53 333	29 667	29 333	21 333	22 333
Үхрийн шир	62 000	62 000	41 667	42 833	32 000	30 667	36 667	37 333
Хонины арьс	4 500	4 600	1 500	1 167	2 000	2 300	5 000	4 000
Ямааны арьс (ноолууртай)	18 000	20 000	11 667	12 667	18 500	23 500	24 000	27 000
Ямааны ноолуур	65 000	68 000	-	40 000	45 000	48 000	-	-

2017 оны 12-р сарын 28-ны өдрийн үнийн ажиглалтаар “Хүчит шонхор” зах дээр нэг кг тэмээний мах 3200 төгрөг, “Далай ээж” зах дээр гахайн мах 7000 төгрөг, тахианы мах 5500 төгрөгийн ханштай байна.

Нийслэлийн түүхий эдийн захуудын сарын дундаж үнээр тэмээний шир 21000 төгрөг, адууны шир 22333 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай бол 25000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 37333 төгрөг, хонины нэхий 4000 төгрөг, ямааны ноолууртай арьс 27000 төгрөг ханштай байна.

Зураг 10. Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөг




Хүснэгт 9. Нэг кг махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөгөөр


Үхрийн мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	7 335	8 025	7 895	8 330	8 380	8 275	8 225	7 710	7 825	7 245	7 115	7 280
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505

Хонины мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	6 480	7 095	7 060	7 420	7 490	7 470	7 415	6 710	6 540	6 215	6 085	6 245
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140


Зураг 11. Нэг кг хонины махны дундаж үнэ



Зураг 12. Нэг кг үхрийн махны дундаж үнэ



Зураг 13. Шатахууны үнэ, өөрчлөлт орсон өдрөөр




Хүснэгт 10. Түлшний үнэ, төгрөг

Байршил	2015.XII.30			2016.XII.28			2017.XII.27		
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) (12-14 кг)	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) (12-14 кг)	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) (12-14 кг)
	Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод	
Чингэлтэй	1 800		2 000	1 800		2 000	2 200		3 200
Сүхбаатар	1 500		2 200	1 700		2 200	2 400		3 200
Цайз зах	1 500		2 000	1 700		1 900	2 200	2 000	3 000
Хангай зах	1 500		2 000	1 800		1 800	2 300		3 000
Дундаж үнэ	1 575		2 050	1 750		1 975	2 275	2 000	3 100

Хүснэгт 11. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2016.XII.28					2017.XII.27				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1 730		1 530	1 640		1 820		1 630	1 720	
Петровис	1 730	1 450	1 530	1 640		1 820	1 480	1 630	1 720	
Магнай трейд	1 730	1 450	1 530	1 640		1 820	1 480	1 630	1 720	
Сод монгол	1 730		1 550	1 640		1 820		1 630	1 720	
Шунхлай		1 450	1 530	1 640				1 630	1 720	
Юнигаз					900					1 050
Дундаж үнэ	1 730	1 450	1 534	1 640	900	1 820	1 480	1 630	1 720	1 050

Зураг 14. Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш, төгрөг²



² Мэдээлийн эх сурвалж: Монголбанкны статистикийн мэдээлэл

Хүснэгт 12. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2017 оны X, XI, XII сарын өдрүүдээр

		хэмжих нэгж	2017 X.11	2017 X.18	2017 X.25	2017 XI.01	2017 XI.08	2017 XI.15	2017 XI.22	2017 XI.29	2017 XII.06	2017 XII.13	2017 XII.20	2017 XII.27	XII.27 XII.20	
1	"Алтан тариа" гурил	дээд	кг	1 305	1 305	1 305	1 305	1 305	1 305	1 305	1 305	1 305	1 305	1 305	100.0	
		1-р зэрэг	кг	1 075	1 075	1 075	1 075	1 075	1 075	1 075	1 075	1 075	1 075	1 075	1 075	100.0
2	"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1 640	1 640	1 640	1 640	1 640	1 640	1 640	1 640	1 640	1 640	1 640	100.0	
		дээд	кг	1 350	1 350	1 350	1 350	1 350	1 350	1 350	1 350	1 350	1 350	1 350	100.0	
		1-р зэрэг	кг	1 100	1 100	1 100	1 100	1 100	1 100	1 100	1 100	1 100	1 100	1 100	100.0	
		2-р зэрэг	кг	870	870	870	870	870	870	870	870	870	870	870	100.0	
3	"Алейка" дээд гурил	кг	1 310	1 310	1 310	1 310	1 310	1 310	1 310	1 310	1 310	1 310	1 310	1 310	100.0	
4	Сүү	Сүү ХК 1л	литр	2 215	2 225	2 225	2 300	2 300	2 300	2 340	2 355	2 355	2 370	2 370	2 380	100.4
		Сүү ХК 0.5л	литр	925	925	925	935	940	940	955	955	955	955	955	955	100.0
		Задгай	литр	1 400	1 400	1 400	1 400	1 400	1 400	1 400	1 400	1 450	1 450	1 450	1 600	110.3
5	Тараг, Цөцгийтэй	литр	2 350	2 350	2 350	2 370	2 425	2 425	2 425	2 425	2 425	2 430	2 430	2 430	100.0	
6	Талх	Атар	ширхэг	1 175	1 175	1 175	1 175	1 175	1 175	1 175	1 175	1 175	1 175	1 175	100.0	
		Зууван чех	ширхэг	1 335	1 335	1 335	1 335	1 335	1 335	1 335	1 335	1 335	1 335	1 335	100.0	
		Хар талх	300 гр	925	925	925	925	925	925	925	925	925	925	925	100.0	
7	Будаа	цагаан	кг	2 660	2 660	2 660	2 660	2 660	2 660	2 660	2 660	2 660	2 660	2 660	100.0	
		шар	кг	1 740	1 740	1 740	1 740	1 740	1 740	1 740	1 740	1 740	1 740	1 740	100.0	
8	Цөцгийн тос, "Сүү" ХК	кг	3 410	3 410	3 410	3 410	3 410	3 410	3 410	3 410	3 410	3 470	3 470	3 470	100.0	
9	Ургамлын тос, "Янта"	1 литр	3 535	3 535	3 535	3 535	3 535	3 535	3 535	3 555	3 555	3 555	3 555	3 555	100.0	
10	Ногоон цай, Гүрж	90 гр	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	100.0	
11	Элсэн чихэр	кг	2 625	2 625	2 625	2 625	2 625	2 625	2 625	2 625	2 625	2 625	2 625	2 625	100.0	
12	Хонины мах	ястай	кг	5 910	5 670	5 555	5 465	5 445	5 390	5 380	5 220	5 210	5 175	5 090	5 090	100.0
		цул	кг	5 800	5 670	5 615	5 515	5 500	5 500	5 470	5 385	5 355	5 285	5 245	5 245	100.0
13	Үхрийн мах	ястай	кг	6 970	6 915	6 900	6 810	6 780	6 700	6 665	6 585	6 540	6 525	6 475	6 475	100.0
		цул	кг	8 325	8 290	8 265	8 225	8 225	8 155	8 155	8 065	8 015	8 015	7 935	7 935	100.0
14	Адууны мах, ястай	кг	5 025	5 025	4 900	4 900	4 900	4 900	4 900	4 900	4 900	4 900	4 900	4 900	100.0	
15	Ямааны мах, ястай	кг	4 235	4 235	3 835	3 835	3 765	3 765	3 765	3 765	3 765	3 535	3 465	3 435	99.1	
16	Төмс, монгол	кг	1 225	1 225	1 225	1 055	1 055	1 055	1 015	1 015	1 015	990	990	950	96.0	
17	Лууван, монгол	кг	1 650	1 560	1 560	1 295	1 295	1 295	1 295	1 295	1 295	1 280	1 280	1 255	98.0	
18	Байцаа, монгол	кг	1 735	1 710	1 710	1 590	1 590	1 590	1 575	1 575	1 575	1 575	1 575	1 550	98.4	
19	Хүрэн манжин, монгол	кг	2 300	2 300	2 300	2 145	2 145	2 145	2 145	2 145	2 145	2 120	2 120	2 010	94.8	
20	Сонгино, хятад	кг	1 370	1 370	1 370	1 345	1 345	1 345	1 345	1 345	1 345	1 345	1 345	1 345	100.0	
21	Алим, фүжи	кг	4 260	4 260	4 260	4 200	4 200	4 200	4 200	4 140	4 140	4 140	4 140	4 140	100.0	
22	Өндөг, ОХУ	ширхэг	285	285	285	285	285	285	285	285	285	285	285	285	100.0	

Хүснэгт 13. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2011-2017 оны XII сарын IV долоо хоногоор

		хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015	2016	XII.27	2017 2016	2017 2015	2017 2014	2017 2013	2017 2012	2017 2011	
1	"Алтан тариа" гурил	дээд	845	842	1 115	1 180	1 265	1 260	1 305	103.6	103.2	110.6	117.0	155.0	154.4	
		1-р зэрэг	696	703	770	1 005	1 070	1 035	1 075	103.9	100.5	107.0	139.6	152.9	154.5	
2	"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	1 044	1 143	1 530	1 625	1 595	1 585	1 640	103.5	102.8	100.9	107.2	143.5	157.1	
		дээд	901	924	1 155	1 225	1 295	1 300	1 350	103.8	104.2	110.2	116.9	146.1	149.8	
		1-р зэрэг	747	788	790	1 035	1 095	1 085	1 100	101.4	100.5	106.3	139.2	139.6	147.3	
		2-р зэрэг	580	592	595	830	835	825	870	105.5	104.2	104.8	146.2	147.0	150.0	
3	"Алейка" дээд гурил	кг	905	1 005	1 345	1 335	1 310	1 305	1 310	100.4	100.0	98.1	97.4	130.3	144.8	
4	Сүү	Сүү ХК 1л		1 576	2 040	2 455	2 090	2 240	2 380	106.3	113.9	96.9	116.7	151.0		
		Сүү ХК 0.5л		646	865	1 215	895	960	955	99.5	106.7	78.6	110.4	147.8		
		Задгай	1 233	1 160	1 450	1 400	1 300	1 250	1 600	128.0	123.1	114.3	110.3	137.9	129.8	
5	Тараг, Цөцгийтэй	литр		1 606	2 040	2 155	2 160	2 085	2 430	116.5	112.5	112.8	119.1	151.3		
6	Талх	Атар	ширхэг	650	658	840	1 065	1 150	1 165	1 175	100.9	102.2	110.3	139.9	178.6	180.8
		Зууван чех	ширхэг		924	930	1 180	1 255	1 215	1 335	109.9	106.4	113.1	143.5	144.5	
		Хар талх	300 гр							925						
7	Будаа	цагаан	1 645	1 725	2 270	2 350	2 500	2 605	2 660	102.1	106.4	113.2	117.2	154.2	161.7	
		шар	1 605	1 635	1 575	1 795	1 695	1 730	1 740	100.6	102.7	96.9	110.5	106.4	108.4	
8	Цөцгийн тос, "Сүү" ХК	кг		2 238	2 250	2 975	3 255	3 255	3 470	106.6	106.6	116.6	154.2	155.0		
9	Ургамлын тос, "Янта"	1 литр							3 555							
10	Ногоон цай, Гүрж	90 гр							1 500							
11	Элсэн чихэр	кг	1 667	1 733	1 665	1 730	1 785	2 315	2 625	113.4	147.1	151.7	157.7	151.5	157.5	
12	Хонины мах	ястай	кг	4 588	6 375	7 410	6 565	4 800	5 210	5 090	97.7	106.0	77.5	68.7	79.8	110.9
		цул	кг	4 733	6 600	7 100	7 100	5 135	5 655	5 245	92.7	102.1	73.9	73.9	79.5	110.8
13	Үхрийн мах	ястай	кг	4 963	7 278	8 010	8 010	6 320	6 135	6 475	105.5	102.5	80.8	80.8	89.0	130.5
		цул	кг	5 538	8 289	9 590	9 735	7 565	7 625	7 935	104.1	104.9	81.5	82.7	95.7	143.3
14	Адууны мах, ястай	кг	3 967	5 514	6 560	5 675	4 775	4 550	4 900	107.7	102.6	86.3	74.7	88.9	123.5	
15	Ямааны мах, ястай	кг	3 540	4 800	5 600	4 900	3 365	3 825	3 435	89.8	102.1	70.1	61.3	71.6	97.0	
16	Төмс, монгол	кг	973	1 030	905	1 135	1 065	750	950	126.7	89.2	83.7	105.0	92.2	97.6	
17	Лууван, монгол	кг	900	1 170	1 300	1 265	1 625	1 020	1 255	123.0	77.2	99.2	96.5	107.3	139.4	
18	Байцаа, монгол	кг	919	1 010	1 250	1 235	1 480	1 300	1 550	119.2	104.7	125.5	124.0	153.5	168.7	
19	Хүрэн манжин, монгол	кг							2 010							
20	Сонгино, хятад	кг	994	1 094	1 290	1 170	1 255	1 255	1 345	107.2	107.2	115.0	104.3	122.9	135.3	
21	Алим, фүжи	кг		3 829	3 610	4 245	3 920	4 170	4 140	99.3	105.6	97.5	114.7	108.1		
22	Өндөг, ОХУ	ширхэг	253	269	415	325	290	275	285	103.6	98.3	87.7	68.7	105.9	112.6	

Хүснэгт 14. Хүнсний барааны үнийн зэрэгцүүлэлт, 2017 оны XII сарын 27-ны өдрийн байдлаар


		хэмжих нэгж	Баян-зүрх зах	Сансар Супер-маркет	Хүчит шонхор зах	Бөмбөгөр ХТ	Меркури зах	Барс ХТ	Таван эрдэнэ зах	Хар-хорин зах	Номин Супер-маркет	Макс Супер-маркет	Оргил Супер-маркет	Е Март	Дундаж үнэ	
1	"Алтан тариа" гурил	дээд	кг	1 300	1 310	1 300	1 300	1 250	1 300	1 300	1 340	1 410	1 266	1 275	1 305	
		1-р зэрэг	кг	1 100	1 060	1 100	1 100	1 100	1 100	1 100	1 040	1 084	1 012	1 030	1 075	
2	"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1 600	1 750	1 550	1 600	1 800	1 500	1 600	1 600	1 699	1 660	1 650	1 700	1 640
		дээд	кг	1 300	1 400	1 350	1 250	1 500	1 300	1 400	1 350	1 299	1 430	1 340	1 300	1 350
		1-р зэрэг	кг	1 100	1 090	1 100	1 000	1 300	1 100	1 100	1 150	1 049	1 110	1 040	1 060	1 100
		2-р зэрэг	кг	900	850	900	900		900	900	900	819	870	820	830	870
3	"Алейка" дээд гурил	кг	1 300	1 300	1 300	1 300		1 300	1 300	1 300	1 349		1 340		1 310	
4	Сүү	Сүү ХК 1л	литр	2 400	2 480	2 400	2 400	2 400	2 300	2 400	2 400		2 330	2 330	2 340	2 380
		Сүү ХК 0.5л	литр	1 000	940	950	950	1 000	900	1 000	950		940	940	940	955
		Задгай	литр	1 500						1 600	1 500	1 800				1 600
5	Тараг, Цөцгийтэй	литр	2 400	2 520	2 500	2 400	2 500	2 400	2 400	2 400		2 410	2 420	2 400	2 430	
6	Талх	Атар	ширхэг	1 200	1 210	1 200	1 100	1 200	1 200	1 200	1 100	1 189	1 220	1 100	1 200	1 175
		Зууван чех	ширхэг	1 400	1 380	1 350	1 250		1 300	1 300	1 250	1 439	1 430	1 300	1 310	1 335
		Хар талх	300 гр	900	950	900	850	1 000	900	950	900	929	970	930	940	925
7	Будаа	цагаан	кг	2 300	2 770	2 200	2 400		2 300	2 200	2 500	3 629	2 800	2 630	3 550	2 660
		шар	кг	1 500	1 770	1 500	1 500		1 500	1 500	1 500	2 129	2 140	1 990	2 130	1 740
8	Цөцгийн тос, "Сүү" ХК	кг	3 500					3 500				3 410			3 470	
9	Ургамлын тос, "Янта"	1 литр	3 500	3 520	3 500	3 500		3 400	3 400	3 500	3 749	3 740	3 750		3 555	
10	Ногоон цай, Гүрж	90 гр	1 500	1 550	1 500	1 400		1 500	1 500	1 500		1 540	1 530		1 500	
11	Элсэн чихэр	кг	2 200	3 000	2 300	2 300	2 500	2 300	2 400	2 300		3 670	2 920	2 960	2 625	
12	Хонины мах	ястай	кг	3 900		3 700	4 800	5 500	4 500	4 800	3 900	6 999	4 910	7 500	5 500	5 090
		цул	кг	4 800		4 500	5 500		5 500	5 800	4 800		5 800			5 245
13	Үхрийн мах	ястай	кг	5 200		4 900	6 500	6 800	6 000	6 000	5 100	8 299	6 250	8 500	7 700	6 475
		цул	кг	6 500		6 500	8 000	8 500	7 500	7 800	6 800	8 999	7 990	10 000	8 700	7 935
14	Адууны мах, ястай	кг	4 800		4 800	5 000				5 000					4 900	
15	Ямааны мах, ястай	кг	3 400		3 400					3 500					3 435	
16	Төмс, монгол	кг	900	890	800	900	1 300	800	800	800	990	1 100	1 210	890	950	
17	Лууван, монгол	кг	1 000	1 250	1 000	1 200	1 500	900	1 000	1 000	1 599	1 499	1 699	1 400	1 255	
18	Байцаа, монгол	кг	1 500	1 500	1 300	1 500	1 800	1 200	1 500	1 500	1 749	1 800	1 799	1 450	1 550	
19	Хүрэн манжин, монгол	кг			2 000	2 000	2 500	1 800	2 000		1 999	1 999	1 800		2 010	
20	Сонгино, хятад	кг	1 300	1 250	1 000	1 300	1 500	1 200	1 500	1 200	1 499	1 300	1 590	1 480	1 345	
21	Алим, фүжи	кг	4 000	4 000	4 000	4 000		4 000	4 000	4 000	3 999	4 500	4 900		4 140	
22	Өндөг, ОХУ	ширхэг	280	340	260	240	300	230	260	280	319	310	300	300	285	



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2017 онд 7043 болж, өмнөх оноос 4945 хүнээр (41.3%) бүүрчээ. Нийт ажилгүйчүүдийн 3965 (56.3%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 15. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 1334 (18.9%) нь 15-24 насны, 3020 (42.9%) нь 25-34 насны, 1490 (21.2%) нь 35-44 насны, 1199 (17.0%) нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 1624 (23.1%) нь Сонгинохайрхан, 1387 (19.7%) нь Баянзүрх, 1153 (16.4%) нь Сүхбаатар, 921 (12.1%) нь Баянгол, 661 (9.4%) нь Хан-Уул, 645 (9.2%) нь Чингэлтэй, 357 (5.1%) нь Багануур, 169 (2.4%) нь Налайх, 126 (1.8%) нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2017 онд ажилгүй 4686 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 2654 иргэн ажилд зуучлагдан орж, 1948 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 15. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, 2018 оны 1-р сарын 1-ний байдлаар

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2015	2016	2017	2015	2016	2017
Ажилгүйчүүд, бүгд	12 640	11 988	7 043	100.0	100.0	100.0
Үүнээс: дээд боловсролтой	4 595	5 238	3 301	35.7	43.7	46.9
Тусгай дунд боловсролтой	822	747	379	6.6	6.2	5.4
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	611	583	249	5.0	4.9	3.5
Ерөнхий боловсролтой	6 546	5 375	3 062	52.2	44.8	43.5
Мэргэжилгүй	66	45	52	0.5	0.4	0.7

2017 онд 32206 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оноос 11142 хүнээр (25.7%) бүүрчээ.

2017 онд 9975 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 0.7 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 12.0 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 87.3 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.



ЭРҮҮЛ МЭНД

2017 онд 38404 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оноос 2283 (5.6%) хүүхдээр цөөн байна.

Төрсөн нийт хүүхдийн 5952 (18.5%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлсэн байна.


Хүснэгт 16. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл

Үзүүлэлт	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
Амаржсан эхийн тоо	41 427	40 425	38 115	94.3
Амьд төрсөн хүүхэд	41 786	40 687	38 404	94.4
Эхийн эндэгдэл	12	17	12	70.6
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	613	611	489	80.0
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	14.7	15.0	12.7	84.7

Нялхсын эндэгдлийн 83 (25.9%) нь Баянзүрх, 81 (25.3%) нь Сонгинохайрхан, 44 (13.8%) нь Хан-Уул, 33 (9.8%) нь Сүхбаатар, 31 (9.7%) нь Баянгол, 24 (7.5%) нь Чингэлтэй, 10 (4.1%) нь Налайх, 8 (2.5%) нь Багануур, 3 (0.9%) нь Багахангай дүүрэгт тус тус гарсан байна. Нялхсын эндэгдлийн 169 (52.8%) нь бусад аймгийн харьяат байна. Өмнөх оноос нялхсын эндэгдэл 3.4 промилээр буурчээ.

Нийслэлд 2017 онд 26808 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оноос 12709 (32.2%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 100.4 продицилээр буурчээ.

Зураг 16. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 22.0 хувийг салхин цэцэг, 15.9 хувийг гар хөл амны өвчин, 12.7 хувийг цусан суулга, 11.6 хувийг тэмбүү, 8.4 хувийг сүрьеэ, 7.5 хувийг трихомониаз, 6.3 хувийг улаан эсэргэнэ, 6.6 хувийг заг хүйтэн, 1.2 хувийг вируст гепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 17. Нийслэлд гарсан халдварт өвчин

Төрөл	хэмжих нэгж	2015	2016	2017	Өсөлт, бууралт 2016-2017	
					тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн	бодит тоо 10000 хүнд	39 925 309.5	39 517 297.1	26 808 196.7	- 12 709 - 100.4	- 32.2
Үүнээс:						
Вируст хепатит	бодит тоо 10000 хүнд	523 4.1	350 2.6	327 2.4	- 23 - 0.2	- 6.6
Цусан суулга	бодит тоо 10000 хүнд	2 336 18.1	2 448 18.4	3 398 24.9	950 6.5	38.8
Салхин цэцэг	бодит тоо 10000 хүнд	3 329 25.8	3 696 27.8	5 893 43.2	2 197 15.4	74.9
Гахай хавдар	бодит тоо 10000 хүнд	159 1.2	249 1.9	120 0.9	- 129 - 1.0	- 51.8
Сальмонеллөз	бодит тоо 10000 хүнд	105 0.8	164 1.2	161 1.2	- 3 -	- 1.8
Улаан эсэргэнэ	бодит тоо 10000 хүнд	674 5.2	1 268 9.5	1 681 12.3	413 2.8	32.6
Улаан бурхан	бодит тоо 10000 хүнд	19 427 150.5	15 962 120.0	7 0.1	- 15 955 - 119.9	- 100.0
Хоолны хордлого	бодит тоо 10000 хүнд	376 2.9	386 2.9	89 0.7	- 297 - 2.2	- 76.9
Ёлом	бодит тоо 10000 хүнд	104 0.8	120 0.9	174 1.3	54 0.4	45.0
Бруцеллөз	бодит тоо 10000 хүнд	17 0.1	19 0.1	34 0.2	15 0.1	44.1
Гар хөл амны өвчин	бодит тоо 10000 хүнд	1 205 9.3	4 520 34.0	4 262 31.3	- 258 - 2.7	- 5.7
Тэмбүү	бодит тоо 10000 хүнд	4 154 32.2	3 086 23.2	3 122 22.9	36 - 0.3	1.2
Заг хүйтэн	бодит тоо 10000 хүнд	2 122 16.4	2 023 15.2	1 767 13.0	- 256 - 2.2	- 12.7
Трихомониаз	бодит тоо 10000 хүнд	1 950 15.1	2 080 15.6	2 013 14.8	- 67 - 0.8	- 3.2
Сүрьеэ	бодит тоо 10000 хүнд	2 537 19.7	2 469 18.6	2 261 16.6	- 208 - 2.0	- 9.2
ДОХ	бодит тоо 10000 хүнд	18 0.1	26 0.2	25 0.2	- 1 -	- 4.0



НИЙГМИЙН ДААТГАЛ

2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 26.9 мянган байгууллагын 648.2 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 432.1 мянга (66.7%) нь аж ахуйн нэгж байгууллагын, 120.8 мянга (18.6%) нь төсөвт байгууллагын, 95.3 мянга (14.7%) нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оноос 26.1 мянган хүнээр (4.2%) нэмэгджээ.


Зураг 17. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 104.0 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 960.0 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 62.5 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 20.4 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.2 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.1 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.8 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 18. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас 2017 онд даатгуулагч, иргэдэд 1153.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 67.2 хувийг тэтгэврийн, 17.6 хувийг эрүүл мэндийн, 6.8 хувийг ҮОМШӨ-ний, 6.2 хувийг тэтгэмжийн, 2.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 12 дугаар сард 160.9 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 648.5 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 76.1 хувийг өндөр насны, 9.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.2 хувийг тэжээгчээ алдсаны, 10.9 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2017 онд 8375.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 9224.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад үйлдвэрлэлт 20.9 хувиар, борлуулалт 19.9 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх онтой харьцуулахад цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 7.2 хувиар, уул уурхайн олборлох үйлдвэрлэлт 20.5 хувиар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 14.4 хувиар, боловсруулах үйлдвэрлэлт 28.7 хувиар тус тус өссөн байна.


Зураг 19. Аж үйлдвэрийн 2016-2017 оны үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг




Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2017 оны 12-р сард 707.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхайн олборлох салбар 57.8 хувийг, цахилгаан дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 12.3 хувийг, боловсруулах үйлдвэрлэлт 29.9 хувийг тус тус эзэлж байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтөд хүнсний үйлдвэрлэлт, тамхи үйлдвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, хувцас үйлдвэрлэлт, арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, мод, модон эдлэл үйлдвэрлэлт, цаас цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэлт, эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэлт, тээврийн бусад хэрэгслийн үйлдвэрлэлт, мебель тавилга үйлдвэрлэлт болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт голлон нөлөө үзүүлсэн байна.


Зураг 20. Махны үйлдвэрлэлт, мянган тонн




Зураг 21. Гурил үйлдвэрлэлт, мянган тонн



Зураг 22. Талх, архи дарсны үйлдвэрлэлт




Зураг 23. Нүүрс олборлолт, мянган тонн




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 4124.5 тэрбум төгрөгийг дотоодод, 5100.0 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.

2017 онд борлуулсан нийт бүтээгдэхүүний 55.3 хувийг экспортоор гаргасан байна. Нийт экспортын 9.7 хувийг нүүрс олборлолт, 17.9 хувийг газрын тос шатдаг хий олборлолт, 46.6 хувийг төмрийн хүдэр олборлолт, 0.9 хувийг бусад ашигт малтмал олборлолт, 4.5 хувийг нэхмэлийн үйлдвэрлэлт, 0.2 хувийг арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, 0.7 хувийг хүнсний үйлдвэрлэлт, 0.1 хувийг тамхи үйлдвэрлэлт, мод модон эдлэл болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 19.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 24. Үйлдвэрлэлт, 2015-2017 он, тэрбум төгрөг



Зураг 25. Борлуулалт, 2015-2017 он, тэрбум төгрөг



Хүснэгт 18. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүн, оны үнээр

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
	сая төгрөг		
Бүгд	6 927 222.0	8 375 304.8	120.9
Уул уурхай, олборлолт	4 534 498.6	5 463 934.9	120.5
Нүүрс олборлолт	526 797.8	950 861.8	180.5
Газрын тос, шатдаг хий олборлолт	746 165.7	927 170.3	124.3
Төмрийн хүдэр олборлолт	3 194 715.1	3 497 393.4	109.5
Бусад ашигт малтмал олборлолт	66 820.0	88 509.4	132.5
Боловсруулах үйлдвэрлэл	1 616 441.2	2 079 558.3	128.7
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	887 384.2	1 014 931.4	114.4
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	73 419.2	106 752.7	145.4
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	62 192.9	106 571.8	171.4
Үр тарианы гурил, малын тэжээл	141 259.2	161 372.4	114.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн	102 995.8	124 040.8	120.4
Ундаа үйлдвэрлэл	507 517.1	516 193.7	101.7
Тамхи үйлдвэрлэл	22 265.3	24 893.8	111.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	411 714.3	431 371.5	104.8
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	9 566.3	18 691.4	195.4
Арьс шир боловсруулах үйлдвэр	12 317.5	21 954.5	178.2
Мод модон эдлэл үйлдвэрлэл	7 706.5	12 744.1	165.4
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 782.2	14 443.1	164.5
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	26 671.4	25 992.9	97.5
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	47 113.7	90 081.2	191.2
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	21 487.3	21 004.6	97.8
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	33 201.0	42 842.1	129.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	1 083.1	1 425.8	131.6
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2 719.1	3 445.0	126.7
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	124 429.3	355 736.9	2.9*
Цахилгаан, дулаан, усан хангамж	776 282.2	831 811.6	107.2
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	731 773.1	782 906.2	107.0
Ус ариутгал, усан хангамж	44 509.1	48 905.4	109.9

*дахин

Хүснэгт 19. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүн, оны үнээр

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2016	2017	$\frac{2017}{2016}$ %	үүнээс: экспорт, %
	сая төгрөг			
Бүгд	7 692 580.9	9 224 451.8	119.9	55.3
Уул уурхай, олборлолт	5 128 743.5	5 497 525.4	107.2	69.7
Нүүрс олборлолт	496 325.4	628 654.5	126.7	78.5
Газрын тос, шатдаг хий олборлолт	732 108.5	911 612.9	124.5	100.0
Төмрийн хүдэр олборлолт	3 838 905.5	3 868 845.1	100.8	61.5
Бусад ашигт малтмал олборлолт	61 404.1	88 412.9	144.0	54.7
Боловсруулах үйлдвэрлэл	1 787 555.2	2 895 060.1	162.0	43.8
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	951 188.0	1 182 652.8	124.3	3.1
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	83 976.1	109 402.7	130.3	30.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	68 087.1	111 091.7	163.2	
Үр тарианы гурил, малын тэжээл	143 235.3	180 517.0	126.0	0.9
Хүнсний бусад бүтээгдэхүүн	107 438.6	139 990.4	130.3	
Ундаа үйлдвэрлэл	548 450.9	641 651.0	117.0	0.3
Тамхи үйлдвэрлэл	75 656.7	83 972.0	111.0	6.0
Нэхмэлийн үйлдвэрлэлт	360 717.5	361 156.4	100.1	63.8
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	10 853.0	18 753.4	172.8	
Арьс шир боловсруулах үйлдвэр	12 524.5	22 570.0	180.2	56.1
Мод модон эдлэл үйлдвэрлэл	8 777.5	12 820.0	146.1	0.7
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 815.1	14 767.9	167.5	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	29 380.7	26 182.5	89.1	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	53 315.7	103 562.3	194.2	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	21 495.5	21 848.6	101.6	
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	36 020.9	45 735.0	127.0	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	1 108.7	1 640.9	148.0	
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2 865.4	3 541.4	123.6	
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	214 836.0	995 856.9	4.6*	98.8
Цахилгаан, дулаан, усан хангамж	776 282.2	831 866.3	107.2	
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	731 773.1	782 959.2	107.0	
Ус ариутгал, усан хангамж	44 509.1	48 907.1	109.9	

* дахин



НИЙТИЙН ТЭЭВЭР


2017 онд Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 3.7 мянган км урттай, 121 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулж, иргэдэд хүргэсэн байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний “үндсэн чиглэл”-ийн тоо өмнөх оноос 2.8 хувиар нэмэгдсэн хэдий ч хот доторх автобусны чиглэлийн урт 45.1 км-ээр багасчээ.

Зураг 26. Зорчигч тээврийн чиглэлийн тоо




Зураг 27. Зорчигч тээврийн чиглэлийн урт



2017 онд Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээг 39 аж ахуйн нэгж эрхлэн явуулсан нь өмнөх оноос 2 аж ахуйн нэгжээр цөөрсөн байна. Тухайлбал, бага, дунд багтаамжийн автобусаар үйлчлэгч аж ахуйн нэгжийн тоо 11.1 хувиар, такси үйлчилгээ эрхлэгчдийн тоо 8.3 хувиар буурчээ. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн дийлэнх хэсгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд эзэлсэн хэвээр байна.

Зураг 28. Зорчигч тээврийн үйлчилгээний салбарт ажиллаж буй ААН-ийн тоо, 2017 он



Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд 2017 онд 667.1 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор 196.2 сая хүн тээвэрлэж, 81.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Зорчигчдын тоо өмнөх оноос 48.1 сая (19.7%) хүнээр буурч, үйлчилгээний орлого 5.3 тэрбум (6.9%) төгрөгөөр өсчээ. Энэ нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг нийслэлийн төсвөөс олгох болсноор үйлчилгээ эрхлэгчдийн хувьд шугамын орлогыг нэмэгдүүлэх, зорчигчдыг суулгах сонирхол буурч, үр ашиг багатай зорчилт хийх болсон.
- Чиглэл, маршрутын шинэчилсэн төлөвлөлтийн хүрээнд зүүн гарын эргэлт болон чиглэлийн давхцалыг бууруулах үүднээс зарим чиглэлийг богино эргэлтээр эргүүлэх болж, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор шаардлагатай хэсгийн хүн урсгалын төвлөрөл, цэгүүдэд зогсоол буудлыг шийдэж өгөөгүйгээс иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчих эрэлтийг бүрэн хангаж чадахгүйд хүрсэн нь зорчигчийн тоо буурахад голлон нөлөөлжээ.
- Эдгээрээс гадна цахим систем нь хөнгөлөлтөөр зорчигч иргэдийн “бодит зорчилт”-ыг бүрэн бүртгэж эхэлсэн нь нөхөн олговроор зорчигчдын тоог бууруулж, улмаар үйлчилгээний төлбөрт төрөөс олгодог нөхөн олговрын хэмжээг багасгах эерэг нөлөөг ч үзүүлэх болсон байна.


Хүснэгт 20. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2017 он

Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Орлого (тэрбум төгрөг)	Зорчигч (сая хүн)			Зорчигч (сая хүн)	Төлбөр (тэрбум төгрөг)		
			карт	бэлэн мөнгө	нөхөн олговор		карт	бэлэн мөнгө	нөхөн олговор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТҮГ)	1	26.6	14.4	2.83	9.4	66.7	40.0	7.64	19.1
Автобус (хувийн)	18	53.6	28.8	3.75	21.05	126.4	76.1	9.9	40.4
Троллейбус (хувийн)	1	0.4	0.23	0.03	0.14	1.3	0.9	0.10	0.3
Бага багтаамжийн автобус	8	1.02	-	1.02	-	1.84	-	1.84	-
Дүн	28	81.6	43.4	7.6	30.6	196.2	117.0	19.5	59.8

2017 онд бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 53.2 хувийг цахим картын орлого, 9.3 хувийг бэлэн мөнгө, 37.5 хувийг “нөхөн олговор”-ын орлого тус тус эзэлж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт болох тээсэн зорчигч болон үйлчилгээний орлогын зонхилох хэсэг нь их, дунд багтаамжийн автобусны үйлчилгээнд ногдож байна. Тухайлбал, 2017 онд нийт 182.0 сая хүн (92.8%) их, дунд багтаамжийн автобусаар зорчиж, үйлчилгээний нийт орлогын 93.8 хувийг бүрдүүлжээ. Цахилгаан тээврийн хувьд зорчигчдын 6.3 хувь, тээврийн орлогын 5.0 хувь нь тус тус ногдож байна.

Зураг 29. Зорчигчдын үндсэн үзүүлэлт, төлбөрийн хэлбэрээр, 2017 он




Нийтийн тээврээр зорчигчдын 59.6 хувь нь цахим картаар үйлчлүүлсэн байхад 9.9 хувь нь бэлэн мөнгө төлж зорчсон байна. Хөлс төлөлтийн цахим картаар үйлчлүүлсэн нийт зорчигчдын 91.1 сая (77.9%) нь насанд хүрэгчид байхад “бэлэн мөнгө төлсөн” зорчигчдын 4.0 сая (20.7%) гаруй нь хүүхдүүд байна.

Мөн цахим системийн бүртгэлээр зорчигчдын 15.9 хувийг ахмад настнууд, 5.5 хувийг оюутнууд эзэлж байгаа бол 7.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Нийт зорчигчдын 30.5 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Өөрөөр хэлбэл, давхардсан тоогоор 2017 онд нийтийн тээврийн хэрэгслээр 59.8 сая хүн үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 30.6 тэрбум төгрөгийг тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд нөхөн олговор хэлбэрээр шилжүүлсэн байна.


Зураг 30. Дамжин суултаар зорчигчид, хувиар




2017 онд тээвэрлэсэн нийт зорчигчдын 11.4 сая (5.8%) шахам нь дамжин суултаар зорчилт хийсэн байна. Тухайлбал, цахим картаар үйлчлүүлсэн 8.9 сая хүний 63.2 хувийг насанд хүрэгчид эзэлжээ.

Харин нөхөн олговрын хөнгөлөлт эдэлж, дамжин суулт хийсэн зорчигчдын 11.2 хувь нь ахмад настнууд, 6.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байв.

Зураг 31. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 32. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр



Нийтийн тээврийн парк шинэчлэлт 2017 онд нийтдээ 374 тээврийн хэрэгслээр хийгдсэний 97.6 хувийг “нөхөн хангалт” (их багтаамжийн хуучин 137 автобус, 220 такси, 2 троллейбус, дунд багтаамжийн 6 автобус) эзэлж байгаа бөгөөд дунд багтаамжийн шинэ 9 автобус үйлчилгээнд шинээр нэмэгджээ.

Харин стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 532 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн хувийн хэвшлийн 175, дунд, бага багтаамжийн 125 автобус, 232 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

Хүснэгт 21. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2016	2017
Бүгд		1850	1950
Их багтаамжийн автобус	Төрийн өмч	312	270
	Хувийн өмч	891	877
Дунд багтаамжийн автобус	Төрийн өмч	-	30
	Хувийн өмч	-	9
Троллейбус	Төрийн	48	42
	Хувийн	8	8
Угсраа автобус		20	20
Бага багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	29	11
	Бүүхиа чиглэл	13	93
Такси		529	590

Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь зориулалтын 1950 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Эдгээрийн 5.3 хувь нь бага багтаамжийн автобус, 2.0 хувь нь дунд багтаамжийн, 58.8 хувь нь их багтаамжийн автобус, 30.3 хувь нь такси байна.

Шугаманд өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 884 автобус, 16 угсраа автобус, 37 троллейбус, бага багтаамжийн 109 автобус ажиллажээ.


Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 69.7 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Зураг 33. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

Зураг 34. Хүлээлтийн хугацаа, минут



Зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацааг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад бага багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаа 15.1 минутаар, хот орчмын үйлчилгээнд ажилласан дунд багтаамжийн автобусных 5.8 минутаар нэмэгдэж, хот доторх шугамын үйлчилгээний их багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаа ойролцоо хэмжээнд, угсраа автобус, цахилгаан тээвэр болон хот орчмын шугаманд ажилласан их багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Автобусны зогсоол:

Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолуудын байршлыг тогтоож баталгаажуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлагад нийцүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн Тээврийн газраас мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтран 2017 оны 10 дугаар сард үзлэг зохион байгуулсан байна.

2017 онд нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээнд өдөр тутам ашиглагдаж байсан 931 автобусны зогсоолыг тус үзлэгт бүрэн хамруулжээ. Нийт зогсоолын 6.1 хувийг “эцсийн зогсоол”, 93.9 хувийг “дундын зогсоол” эзэлж байгаа юм.

Хүснэгт 22. Автобусны зогсоолын тоо, төвийн 6 дүүрэг, үзлэг хийгдсэн оноор

Дүүрэг	2009			2013			2017		
	Бүгд	эцсийн зогсоол	дундын зогсоол	Бүгд	эцсийн зогсоол	дундын зогсоол	Бүгд	эцсийн зогсоол	дундын зогсоол
Баянгол	56	1	55	76	3	73	51	2	49
Баянзүрх	132	16	116	190	19	171	211	15	196
Сонгинохайрхан	138	20	118	195	25	170	216	18	198
Сүхбаатар	50	1	49	119	5	114	183	7	176
Хан-Уул	79	9	70	65	9	56	187	9	178
Чингэлтэй	114	13	101	72	7	65	83	6	77
Нийт	569	60	509	717	68	649	931	57	874

2013 онд хийгдсэн автобусны зогсоолын үзлэгийн дүнтэй харьцуулахад нийт зогсоолын тоо 2017 онд 29.8 хувиар нэмэгдсэн хэдий ч эцсийн зогсоолын тоо 16.2 хувиар буурчээ. Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн 57 зогсоолын 89.5 хувийг (51) барилга байгууламжгүй зогсоол эзэлж байна. Зорчигчид бууж, суух тусдаа хүлээлгийн талбайтай 34 (59.6%) зогсоол байгаагийн 20 (58.8%) нь стандартын шаардлага хангасан байхад хяналтын камертай 11 (19.3%), хүлээлгийн талбай нь хатуу хүчилтэй 38 (66.7%), сайжруулсан шороон 8 (14%), бусад шороон 10 (17.5%) зогсоол байна.

Нийслэлд ажиллаж буй автобусны дөрвөн зогсоол тутмын нэг нь буюу хамгийн олонх нь нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байршиж байна. Мөн автобусны таван зогсоол тутмын нэг нь Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт, хамгийн цөөн буюу 51 буудал Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байршиж байна.


Хүснэгт 23. Автобусны “дундын зогсоол”-ын зарим үзүүлэлт, төвийн 6 дүүргээр, 2017 он

Дүүрэг	Бүгд	Үүнээс: Стандарт хангасан									
		Зогсоолын талбайтай		Зогсоолын тэмдэгтэй		Саравчтай		Нийтийн сандалтай		Орчны гэрэлтүүлэгтэй	
		нийт	хувь	нийт	хувь	нийт	хувь	нийт	хувь	нийт	хувь
Баянгол	49	19	44.9	41	83.7	29	59.2	32	65.3	48	98.0
Баянзүрх	196	135	68.9	142	72.4	45	23.0	54	27.6	157	80.1
Сонгинохайрхан	198	22	11.1	97	49.0	37	18.7	30	15.2	184	92.9
Сүхбаатар	176	29	16.5	118	67.0	31	17.6	31	17.6	170	96.6
Хан-Уул	178	43	24.2	143	80.3	45	25.3	50	28.0	124	69.7
Чингэлтэй	77	59	76.6	61	79.2	22	28.6	23	29.9	76	98.7
Нийт	874	307	35.5	602	68.9	209	23.9	220	25.2	759	86.8

Нийтийн тээврийн үйлчилгээний дундын нийт зогсоолын 703 (80.4%) нь автобус зогсох зориулалтын талбайтайгаас 307 (43.7%) нь стандартын шаардлага хангасан байхад 209 (23.9%) нь саравчтай, 759 (86.8%) нь орчны гэрэлтүүлэгтэй, 602 (68.9%) нь стандарт хангасан автобусны зогсоолын тэмдэгтэй байв.

Түүнчлэн дундын дөрвөн зогсоол тутмын зөвхөн нэг нь стандарт хангасан нийтийн сандалтай, 158 зогсоол (18%) мэдээллийн самбартай байгаа нь нийслэлийн иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээний мэдээлэл дутмаг хүрч байгааг нөгөөтэйгүүр зорчигчдын тав тухтай байдлыг хангахгүй байгааг илтгэх үзүүлэлтүүд юм.


Зураг 35. Зогсоол хоорондын зай, 2013, 2017 он



Нийтийн тээврийн үйлчилгээний дундын нийт зогсоолын 620 (70.9%) нь шаардлага хангасан³ буюу зогсоол хоорондын зай нь 400-600 метр зайтай байрласан байна. Харин хот орчмын алслагдсан чиглэлүүдийн хувьд зогсоол хоорондын зай дунджаар 800-1600 метр байгаа юм.

Дээрх үзүүлэлтийг 2013 оны үзлэгийн дүнтэй харьцуулахад хувийн жинд нь өөрчлөлт ороогүй боловч стандарт хангасан автобусны зогсоолын тоо 116-аар нэмэгдсэн байв.

Зураг 36. Уулзвар гарцтай ойр байрласан эсэх



Нийтийн тээврийн үйлчилгээний дундын нийт зогсоолын 742 (84.9%) нь шаардлага хангасан⁴ буюу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байна. Өөрөөр хэлбэл, дундын дийлэнх зогсоолууд уулзвараас 30м-40м-ээс хол зайд байрласан ажээ.


Нийтийн тээврийн үйлчилгээний 16 стандарт үзүүлэлтийн дагуу хийгдсэн дээрх үзлэгийн дүнгээр дундын нийт 874 зогсоолын 115 (13.2%) нь стандартын шаардлага хангаж байгаа юм. Тодруулбал, шалгуур болгосон 16 стандартаас 13-ыг хангасан тохиолдолд шаардлага хангасан гэж үзсэн байна.

³ Монгол Улсын “Нийтийн тээвэр, Замналын зогсоол, Ангилал, Техникийн шаардлага” MNS 5879:2012-ын 7.5 дахь шаардлага

⁴ Монгол Улсын “Нийтийн тээвэр, Замналын зогсоол, Ангилал, Техникийн шаардлага” MNS 5879:2012-ын 8.1 дэх шаардлага

2017 онд нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 2458 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсэний 89.5 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна.

Зураг 37. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын барагдуулалт



Зураг 38. Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх санал, гомдол, 2017 он





ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТО МАШИН

Техникийн хяналтын улсын үзлэгийн дүнд үндэслэн тооцоход сүүлийн 5 жилд нийслэлийн автомашины жилийн дундаж өсөлт 9.8 хувьтай байна. Тухайн жилийн өсөлтөөр нь авч үзвэл 2012 онд 9.1, 2013 онд 12.5, 2014 онд 15.3, 2015 онд 11.6 хувьтай байсан өсөлт 2016 онд 2.4 хувь болж огцом буурч байв.

2017 онд нийслэлийн автомашины жилийн дундаж өсөлт 7.7 хувь болж, өмнөх оноос 5.3 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 24. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины тоо

Дүүрэг	2013	2014	2015	2016	2017	Үүнээс: үндсэн төрлөөр			
						сүүдлын	ачааны	автобус	тусгай
Нийслэлийн дүн	257 498	297 008	331 564	339 626	365 819	282 182	67 699	9 924	6 014
Багануур	1 622	2 314	2 436	2 688	2 638	1 910	581	121	26
Багахангай	290	435	435	548	692	532	127	28	5
Баянгол	57 291	63 918	65 522	67 658	73 090	56 781	13 151	1 833	1 325
Баянзүрх	64 655	77 148	87 240	91 023	93 714	72 648	17 453	2 181	1 432
Налайх	1 946	2 419	3 073	3 184	3 563	2 557	885	97	24
Сонгинохайрхан	45 198	51 477	56 065	56 851	60 518	46 139	11 936	1 733	710
Сүхбаатар	35 815	39 780	47 746	46 906	54 341	41 593	10 027	1 607	1 114
Хан-Уул	22 208	27 036	32 344	34 444	37 954	29 367	6 386	1 370	831
Чингэлтэй	28 473	32 481	36 703	36 324	39 309	30 655	7 153	954	547

2017 оны техникийн хяналтын үзлэгт нийслэлийн дүнгээр нийтдээ 365.8 мянган автомашин хамрагдсан нь бүртгэлтэй нийт автомашины 76.1 хувийг эзэлж байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 77.2 хувийг сүүдлын автомашин эзэлж байгаа бол 18.5 хувь нь ачааны, 2.7 хувь нь автобус, 1.6 хувь нь тусгай зориулалтын автомашин байна.

Хүснэгт 25. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан амины автомашины тоо

Дүүрэг	2013	2014	2015	2016	2017	Үүнээс: үндсэн төрлөөр			
						сүүдлын	ачааны	автобус	тусгай
Нийслэлийн дүн	203 573	238 183	265 352	275 084	294 472	240633	47 021	5 268	1 550
Багануур	1 365	2 026	2 068	2 293	2 249	1 673	508	60	8
Багахангай	249	382	376	472	639	499	122	15	3
Баянгол	46 413	52 305	53 116	55 137	59 930	50 166	8 540	895	329
Баянзүрх	51 340	61 793	69 667	74 032	80 055	64 964	13 445	1 291	355
Налайх	1 855	2 334	2 916	3 066	3 463	2 503	857	87	16
Сонгинохайрхан	40 853	47 065	51 366	52 491	56 039	44 365	10 005	1 289	380
Сүхбаатар	22 576	25 686	30 711	30 962	31 274	26 133	4 512	504	125
Хан-Уул	16 526	20 910	25 451	27 316	29 077	24 669	3 682	526	200
Чингэлтэй	22 396	25 682	29 681	29 315	31 746	25 661	5 350	601	134


Хувь хүмүүс, иргэдийн эзэмшилд бүртгэлтэй амины автомашины тоо 294.5 мянгад хүрсэн бөгөөд үзлэгт хамрагдсан нийт автомашины 80.5 хувийг эзэлж байна. Амины нийт автомашины 1175 нь нийслэл хотод ажиллаж, амьдарч байгаа гадаадын харьяат иргэдийн эзэмшлийнх ажээ.

Хүснэгт 26. Автомашины тоо, өмчлөлийн хэлбэрээр, 2017 он

Үзүүлэлт	Бүгд	Үүнээс: үндсэн төрлөөр				
		суудлын	ачааны	автобус	тусгай зориулалт	
Нийслэлийн дүн	365 819	282 182	67 699	9 924	6 014	
Аж ахуйн нэгжийн автомашин	төрийн болон орон нутгийн өмчийн	3 976	2 134	614	827	401
	дипломат, олон улсын байгууллагын	546	466	38	37	5
	төрийн бус байгууллагын	3 705	1 832	1 397	193	283
	компани, хоршоо, нөхөрлөлийн	63 120	37 117	18 629	3 599	3 775
Амины автомашин	294 472	240 633	47 021	5 268	1 550	
Үүнээс: гадаадын иргэдийн	1 175	1 087	64	23	1	

2017 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн нийт автомашины 19.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаагийн 1.1 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.1 хувийг дипломат болон олон улсын байгууллагын, 1.0 хувийг төрийн бус байгууллагын, 17.3 хувийг компани, хоршоо, нөхөрлөлийн автомашин түс түс эзэлж байна.

Зураг 39. Суудлын автомашин, маркаар, 2017 он



Нийслэлийн авто замын хөдөлгөөнд идэвхтэй оролцож буй суудлын нийт автомашины тоог маркаар нь ангилж, зурагт харуулав. Эндээс үзвэл хамгийн олон буюу 185.4 мянган “Toyota” маркийн автомашин байна. Удаад нь “Hyundai” (27.0 мянга), гуравт “Nissan” (18.8 мянга), дөрөвт “Honda” (8.8 мянга), тавд “Mitsubishi” (8.2 мянга) маркийн автомашин багтжээ.

Улмаар эхний аравд Lexus, Subaru, Mercedes-Benz, Kia, Suzuki маркийн автомашинууд орж, эдгээр нь “бусад” гэсэн ангилалд оруулсан 33.7 мянга гаруй автомашины 56.8 хувийг эзэлж байв.

Хүснэгт 27. Автомашины тоо, ашиглалтын хугацаагаар, дүүргээр

Дүүрэг	2016				2017			
	Бүгд	0 - 3 жил	4 - 9 жил	10-аас дээш	Бүгд	0 - 3 жил	4 - 9 жил	10-аас дээш
Нийслэлийн дүн	339 626	9 104	74 891	255 631	365 819	8 706	82 861	274 252
Багануур	2 688	28	348	2 312	2 638	20	306	2 312
Багахангай	548	3	110	435	692	2	152	538
Баянгол	67 658	1 576	16 844	49 238	73 090	1 236	18 739	53 115
Баянзүрх	91 023	1 708	19 386	69 929	93 714	1 259	19 805	72 650
Налайх	3 184	27	339	2 818	3 563	13	475	3 075
Сонгинохайрхан	56 851	513	9 803	46 535	60 518	420	11 291	48 807
Сүхбаатар	46 906	2 213	12 035	32 658	54 341	2 492	14 274	37 575
Хан-Уул	34 444	2 336	8 986	23 122	37 954	2 746	10 025	25 183
Чингэлтэй	36 324	700	7 040	28 584	39 309	518	7 794	30 997

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн харьяалал бүхий нийт автомашины ихэнх буюу 75.0 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд эзэлж байна. Энэ ангилалд харьяалагдаж буй 274.2 мянган автомашины 63.7 хувь нь нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт ногдож байгаагийн дотор 26.5 хувь буюу хамгийн олон нь Баянзүрх дүүрэгт байна.


Нийслэлийн нийт автомашины дүнд үйлдвэрлэгдэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил ашиглаж байгаа шинэ автомашины эзлэх хувийн жин 2.4 байгаа нь өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна. Уг ангилалд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн дийлэнх буюу 88.8 хувь нь нийслэлийн Хан-Уул (31.5%), Сүхбаатар (28.6%), Баянзүрх (14.5%), Баянгол (14.2%) дүүрэгт тус тус бүртгэлтэй байна.

Хүснэгт 28. Автомашины тоо, хөдөлгүүрийн шатахууны төрлөөр

Үзүүлэлт	Үүнээс: автомашины үндсэн төрлөөр									
	Бүгд		суудлын		ачааны		автобус		тусгай зориулалт	
	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
Нийт дүн	339 626	365 819	262 341	282 182	61 452	67 699	9 951	9 924	5 882	6 014
Бензин	164 168	163 609	157 990	157 049	4 258	4 503	1 487	1 677	433	380
Дизель	88 945	93 448	18 259	17 946	56 887	61 998	8 373	7 984	5 426	5 520
Хосолсон	74 532	94 333	74 437	93 730	40	405	53	135	2	63
Газ	11 981	14 429	11 655	13 457	267	793	38	128	21	51


Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн 365.8 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь шатахууны төрлөөр ангилж үзэхэд 44.7 хувийг нь “бензин хөдөлгүүр”-тэй автомашин эзэлж, энэ төрлийн автомашины тоо 2016 оноос 0.3 хувиар цөөрчээ. Газ болон хосолсон хөдөлгүүртэй автомашины тоо нэмэгдэх төлөв хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон. 2017 онд дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн эзлэх хувийн жин 25.5 болж, өмнөх онтой харьцуулахад 0.7 пунктээр доогуур байна.

Зураг 40. Автомашины тоо, хөдөлгүүрийн багтаамжаар, 2017 он



Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн 365.8 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь багтаамжаар авч үзэхэд 37.4 хувь нь 1500 см³ хүртэл багтаамжтай автомашин зонхилж, тус ангилалд бүртгэлтэй байгаа нийт автомашины 79.1 хувь нь 2017 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан бол 36.5 хувийг нь 1501-2500 см³ багтаамж бүхий хөдөлгүүртэй автомашин эзэлж байв. Тус ангилалд бүртгэлтэй нийт автомашины 78.0 хувь нь техникийн хяналтын үзлэгт хамрагджээ.

Зураг 41. Автомашины тоо, хүрдний байрлалаар, 2017 он




Жолооны хүрд нь баруун талдаа буюу “баруун талдаа” байрлалтай 230.5 мянга гаруй автомашин техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нь нийт автомашины 63.0 хувийг эзлэх болж, өмнөх оноос 21.2 мянга шахам автомашинаар нэмэгджээ. Эдгээрийн дийлэнх буюу 95.0 хувийг “суудлын автомашин” дангаараа эзэлж байгаа юм.

Суудлын нийт автомашины 77.6 хувь нь баруун талдаа, 22.4 хувь нь зүүн талдаа хүрдний байрлалтай байна.

Зүүн талдаа буюу бидний хэлж заншснаар “зөв талдаа” хүрдний байрлалтай автомашинуудын хувьд суудлын автомашинаас бусад төрлийн тээврийн хэрэгслийн тоо хэмжээ баруун талдаа хүрдний байрлалтай тээврийн хэрэгслээс илүү олон байгаа юм. Тухайлбал, ачааны нийт автомашины 84.8 хувь, автобусны 93.3 хувь, тусгай зориулалтын автомашины 91.9 хувь нь зөв талдаа байрласан жолооны хүрдтэй байна. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөний дүрэмдээ баруун гарын дүрэм (зөв талдаа буюу жолооны хүрд нь зүүн талдаа байрлалтай тээврийн хэрэгсэл ашиглах) баримталдаг манай улс, нийслэлийн хувьд энэ нь эерэг үзүүлэлт юм.

2017 онд нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 291.5 мянга болж, өмнөх онтой харьцуулахад 10.7 хувиар нэмэгджээ. Нийт суурин телефон цэгийн 248.2 мянга (85.1%) нь айл өрхийн эзэмшилд байна. Нийслэлд телефон утас эзэмшигч өрхийн тоо өмнөх оноос 15.1 хувиар өсчээ. Үүнд гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгчдийн тоо өсөн нэмэгдэж байгаа нь голлон нөлөөлж байна.

Зураг 44. Суурин телефон цэгийн тоо



Зураг 45. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо




2017 онд Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.6 сая гаруй хүн үүрэн телефоны хэрэглэгч (идэвхтэй) байгаагийн 1.7 сая гаруй (48.3%) хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх онтой харьцуулахад үүрэн телефоны идэвхтэй хэрэглэгчийн тоо нийслэлд 83.2 мянгаар нэмэгджээ.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 445.8 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1332.8 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна.

Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.5 мянга байгаа нь өмнөх оны түвшинд байна. Түүнчлэн нийслэлд 0.3 мянга орчим хэрэглэгч сансарын холбоог эзэмшиж байна.

Зураг 46. КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



Кабелийн болон Ай Пи телевизийн 18 аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн 425.1 мянга гаруй хэрэглэгчдэд үйлчилж байна.

Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.2 хувийг айл өрх эзэлдэг байна.


Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүрэгт, 2 нь Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.



МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО

Нийслэлийн мал, тэжээвэр амьтдын 2017 оны тооллогоор нийт 423644 толгой мал тоологдсон нь 2016 оноос 14685 толгой малаар (3.4%) бүүрчээ. Улсын хэмжээнд 2017 онд 66219.0 мянган толгой мал тоологдсон бөгөөд нийслэлийн мал 0.6 хувийг эзэлж, өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна.

Зураг 47. Нийслэлийн малын тоо, улсын дүнтэй харьцуулснаар, мянган толгой



Малын таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад тэмээ 4 толгой малаар (1.6%) өсч, адуу 1836 толгой (4.1%), үхэр 955 толгой (1.1%), хонь 6640 толгой (3.8%), ямаа 5258 толгой (4.2%) малаар тус тус буурчээ.

Иргэдийн хувийн мал 413736 толгой, аж ахуйн нэгж, байгууллагын мал 9908 толгой болж өмнөх оноос иргэдийн мал 14633 толгой (3.4%), аж ахуйн нэгж, байгууллагын мал 52 толгой (0.5%) малаар тус тус буурав.

Хүснэгт 29. Малын тоо, төрлөөр

Малын төрөл	2013	2014	2015	2016	2017	Өсөлт, бууралт	
						тоо	Хувь
Малын тоо, бүгд	329 089	385 364	40 3655	438 329	423 644	-14 685	96.6
Тэмээ	120	154	233	247	251	4	101.6
Адуу	30 202	33 864	36 735	45 177	43 341	-1 836	95.9
Үхэр	64 611	76 570	86 006	89 800	88 845	-955	98.9
Хонь	134 616	158 853	162 322	176 813	170 173	-6 640	96.2
Ямаа	99 540	115 923	118 359	126 292	121 034	-5 258	95.8
Хонин толгойд шилжүүлсэнээр ⁵	823 882	960 422	1 043 191	1 146 750	1 116 816	-29 934	97.4

Амины малын тоо: Иргэдийн хувийн өмчийн малын тоо 2017 онд 413736 толгой болж, нийт малын 97.7 хувийг эзэлж байна. Тоологдсон тэмээний 99.6 хувь, адууны 98.8 хувь, үхрийн 98.0 хувь, хонины 96.5 хувь, ямааны 98.6 хувийг хувийн аж ахуйн мал эзэлж байна.

Нийслэлийн малтай нэг өрхөд 82 толгой мал, хонин толгойд шилжсэнээр 217 толгой мал ногдож байгаа бөгөөд малтай өрхийн ам бүлийн нэг хүнд 26 толгой мал, хонин толгойд шилжсэнээр 68 бог мал ногдож байна. Малтай нэг өрхөд ногдох малын тоогоор Багануур дүүрэг (нэг өрхөд 242 толгой мал) тэргүүлж байна.

⁵ Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

2017 онд нийслэлийн 9 дүүргийн малын тоо өмнөх оноос 0.2-9.7 хувиар буурчээ.

Хүснэгт 30. Малтай өрхийн тоо, малын бүлэглэлтээр, 2017 он

Малын бүлэглэлт	Малтай өрхийн тоо	Ам бүлийн тоо	Амины малын тоо	Үүнээс :				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Малын тоо, бүгд	5 144	16 395	413 736	250	42 807	87 087	164 293	119 299
10 хүртэлх	1 582	4 799	9 029	5	693	8 188	58	85
11-30	1 489	4 539	27 502	2	3 275	21 865	970	1 390
31-50	523	1 736	20 669	2	3 742	12 622	1 857	2 446
51-100	559	1 820	40 088	6	7 603	16 436	7 962	8 081
101-200	409	1 473	58 808	3	7 554	9 593	22 351	19 307
201-500	421	1 440	128 812	13	10 930	10 582	59 842	47 445
501-999	127	460	84 083	142	5 825	4 954	44 958	28 204
1000-1499	25	89	29 321	75	1 678	2 142	16 600	8 826
1500-2000	9	39	15 424	2	1 507	705	9 695	3 515

Тоологдсон нийт малын тоогоор Багануур дүүрэг 172049 толгой малаар нийслэлд тэргүүлж байгаа ч өмнөх оноос 6725 толгой малаар буурав. Үхрийн тоогоор Сонгинохайрхан дүүрэг 26529 толгой малаар, бусад малын төрлөөр Багануур дүүрэг тэргүүлж байна.

Хүснэгт 31. Малын тоо, дүүргээр

Дүүрэг	2013	2014	2015	2016	2017	Өсөлт, бууралт
Нийслэлийн дүн	329 089	385 364	403 655	438 329	423 644	96.6
Багануур	122 966	149 123	154 983	178 774	172 049	96.2
Багахангай	20 203	24 914	30 126	31 608	31 548	99.8
Баянзүрх	42 974	46 132	50 129	55 319	54 968	99.4
Налайх	45 160	49 745	52 205	55 804	50 386	90.3
Сонгинохайрхан	56 107	67 959	73 825	73 576	72 072	98.0
Сүхбаатар	3 312	2 953	3 367	3 051	2 888	94.7
Хан-Уул	36 990	42 686	37 520	38 860	38 485	99.0
Чингэлтэй	1 364	1 840	1 500	1 337	1 248	93.3


Мал төллөлт, төл бойжилт:

2017 онд 178159 хээлтэгч мал төллөж, 180301 төл гарсны 174059 төл (96.5%) нь бойжиж байна.

Бойжсон төлийн тоо өмнөх оноос 7886 толгойгоор (4.7%) өсчээ.

Бойжуулсан нийт төлийн 0.02 хувийг ботго, 6.4 хувийг унага, 18.7 хувийг тугал, 44.6 хувийг хурга, 30.3 хувийг ишиг эзэлж байна.

Зураг 48. Бойжуулсан төл, мянган толгой



Хүснэгт 32. Төл бойжилт, Мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээр

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Гарсан төл	132 307	141 592	169 438	170 542	180 301
Бойжсон төл	129 713	139 223	166 830	166 173	174 059
Хорогдсон төл	2 594	2 369	2 608	4 369	6 242
Бойжилтын хувь	98.0	98.3	98.5	97.4	96.5

Том малын зүй бус хорогдол: Оны эхний малын 1.9 хувьтай тэнцэх 8314 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос 1.3 дахин өсчээ. Хорогдсон нийт малын 12.2 хувийг адуу, 26.7 хувийг үхэр, 32.5 хувийг хонь, 28.6 хувийг ямаа эзэлжээ. Том малын зүй бус хорогдлын 1089 (13.1%) нь өвчнөөр хорогджээ.

Хүснэгт 33. Том малын зүй бус хорогдол, дүүргээр

Дүүрэг	2013	2014	2015	2016	2017
Нийслэлийн дүн	3629	2128	2738	6413	8314
Багануур	1686	1106	1023	882	3273
Багахангай	137	38	116	463	372
Баянгол	1	1	6	-	-
Баянзүрх	428	308	377	1678	1066
Налайх	455	101	301	1397	1312
Сонгинохайрхан	640	232	309	1129	1131
Сүхбаатар	42	32	36	96	86
Хан-Уул	231	293	552	751	1070
Чингэлтэй	9	17	18	17	4

Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн мал: 2017 онд нийслэлийн мал эрхлэхийг хориглох бүсэд 15187 толгой мал тоологдож, өмнөх оноос 1517 толгой малаар (9.1%) буурсан байна. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын 6.4 хувийг адуу, 47.6 хувийг үхэр, 19.8 хувийг хонь, 26.2 хувийг ямаа эзэлжээ.

Хүснэгт 34. Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын тоо, дүүргээр

Дүүрэг	2013	2014	2015	2016	2017
Нийслэлийн дүн	15017	15367	14999	16704	15187
Баянгол	13	12	-	-	-
Сүхбаатар	3312	2953	3367	3051	2888
Чингэлтэй	1364	1840	1500	1337	1248
Баянзүрх (11,20-р хороо ороогүй)	3067	1898	2376	3114	3622
Сонгинохайрхан (21,32-р хороо ороогүй)	4769	6422	5024	6677	5015
Хан-Уул (12,13,14-р хороо ороогүй)	2492	2242	2732	2525	2414

Хориглох бүсийн малын тоог өмнөх онтой харьцуулахад Баянзүрх дүүрэгт 508 толгой малаар (16.3%) өсч, Сонгинохайрхан дүүрэгт 1662 толгой малаар (24.9%), Сүхбаатар дүүрэгт 163 толгой малаар (5.3%), Хан-Уул дүүрэгт 111 толгой малаар (4.4%), Чингэлтэй дүүрэгт 89 толгой малаар (6.7%) тус тус буурчээ.

Тэжээвэр амьтад: Мал, тэжээвэр амьтдын 2017 оны тооллогоор 120 өрх, 8 аж ахуйн нэгжийн 14146 гахай, 265 өрх, 12 аж ахуйн нэгжийн 511839 шувуу, үүнээс 510418 тахиа, 5 илжиг, 73 түүлай, 45 минж, 10 бүл зөгий тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад шувууны тоо 94100 (22.5%) өсч, гахайн тоо 6080 (30.1%) буурсан байна.

Хүснэгт 35. Тэжээвэр амьтдын тоо, дүүргээр, 2017 он

Дүүрэг	Гахай	Шувуу	тахиа	Илжиг	Түүлай	Минж	Зөгий
Нийслэлийн дүн	14146	511839	510418	5	79	45	10
Багануур	-	1575	1538	-	-	-	10
Багахангай	33	113	91	-	-	-	-
Баянгол	-	19	17	-	-	-	-
Баянзүрх	237	682	596	2	11	45	-
Налайх	334	146525	146476	1	10	-	-
Сонгинохайрхан	9347	784	537	-	20	-	-
Сүхбаатар	15	868	605	-	-	-	-
Хан-Уул	4174	360722	360201	-	13	-	-
Чингэлтэй	6	551	357	2	19	-	-



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2017 онд нийслэлийн хүн амд 36.5 сая м³ (77.9%), аж ахуйн нэгж, байгууллагад 10.4 сая м³ (22.1%) цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өмнөх оноос 4.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 36. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
Шахсан ус	мянган м ³	53 617.6	52 346.3	52 506.6	52701.1	100.4
Борлуулсан ус	мянган м ³	45 346.5	45 437.5	44 838.1	46882.1	104.6
Хүн амд	мянган м ³	32 579.0	34 213.1	34 316.5	36520.4	106.4
Аж ахуйн нэгж, байгууллагад	мянган м ³	12 767.5	11 224.4	10 521.6	10361.7	98.5
Татан зайлуулсан бохир	мянган м ³	44 206.2	44 311.7	44 767.0	46817.3	104.6
Хүн амаас	мянган м ³	30 220.6	31 725.4	33 104.1	35188.8	106.3
Аж ахуйн нэгж, байгууллагаас	мянган м ³	13 985.6	12 586.3	11 662.9	11628.5	99.7
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	20 819.1	26 533.9	25 923.8	28446.6	109.7
Хүн амаас	сая төгрөг	11 498.9	15 643.9	15 540.2	16580.9	106.7
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төгрөг	9 320.2	10 890.0	10 383.6	11865.7	114.3
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	11 968.1	16 342.3	17 356.1	19236.6	110.8
Хүн амаас	сая төгрөг	5 321.8	7 253.0	8 080.4	8571.9	106.1
Аж ахуйн нэгж, байгууллагаас	сая төгрөг	6 646.3	9 089.3	9 275.7	10664.7	115.0

Хүн амд түгээсэн цэвэр усны 35.2 сая м³ (96.3%) усыг төвлөрсөн шугамаар, 1349.5 мянган м³ (3.7%) усыг ус түгээх байраар, 9.3 мянган м³ (0.03) усыг тээврээр түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжаар 62.0 сая м³ бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 46.8 сая м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 49. Борлуулсан ус, сараар, мянган м³



Зураг 50. Татан зайлуулсан бохир, сараар, мянган м³




АМЬДАРЧ БҮЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2017 оны 12-р сард дунджаар -16.7⁰C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -0.2⁰C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал -0.2⁰C-аар тус тус хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм -1.5⁰C, хамгийн хүйтэн хэм -25.5⁰C, хур тунадасны нийлбэр 2.4 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 10 метр секунд хүрчээ. Цасан бүрхүүлийн үнэмлэхүй зузаан 11 сантиметр, шороон болон цасан шуургатай 2 өдөр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 37. Агаарын бохирдолт, мг/м³, 12-р сард⁶

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	250	0.224	62	0.043
Азотын давхар исэл	NO ₂	0.050	296	0.170	194	0.065
Тоосжилт	PM ₁₀	0.100	299	0.934	242	0.212
	PM _{2.5}	0.050	169	0.569	159	0.174
Нүүрстөрөгчийн дутуу исэл ⁷	CO	10.000	639	13.643	8	2.760
Озон	O ₃	0.100	525	0.058	-	0.015

Зураг 51. Улаанбаатар⁸ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



2017 оны 12-р сард азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж Баруун 4 зам болон 13-р хороолол орчимд тус бүр 31 удаа, Толгойт орчимд 26 удаа, 32-ын тойрог орчимд 25 удаа, Амгалан орчимд 21 удаа, Телевиз орчимд 19 удаа, 1-р хороолол орчимд 17 удаа, Офицеруудын ордон орчимд 12 удаа, Хархорин зах орчимд 7 удаа, Ургах наран хороолол орчимд 5 удаа, хүхэрлэг хийн агууламж Амгалан орчимд 22 удаа, Телевиз орчимд 17 удаа, 32-ын тойрог орчимд 9 удаа, 13-р хороолол орчимд 5 удаа, Баруун 4 зам болон Ургах наран хороолол орчимд тус бүр 3 удаа, 1-р хороолол орчимд 2 удаа, Офицеруудын ордон орчимд 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.


10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 31 удаа, 32-ын тойрог орчимд 29 удаа, Хархорин зах орчимд 27 удаа, Баруун 4 зам болон Телевиз орчимд тус бүр 26 удаа, 1-р хороолол орчимд 25 удаа, Амгалан орчимд 24 удаа, 13-р хороолол орчимд 22 удаа, Мишээл экспо төвийн орчимд 15 удаа, Нисэх орчимд 11 удаа, Ургах наран хороолол орчимд 6 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт болон Телевиз орчимд тус бүр 31 удаа, Амгалан орчимд 30 удаа, Баруун 4 зам орчимд 26 удаа, 13-р хороолол орчимд 24 удаа, Нисэх орчимд 17 удаа, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж Толгойт болон Телевиз орчимд тус бүр 4 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

⁶ Эх үүсвэр: Цаг уур орчны шинжилгээний газар


⁷ 8 цагийн дундаж

⁸ Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдлыг хэмжих харуул цэг байхгүй


Зураг 52. Улаанбаатар³ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Зураг 53. Улаанбаатар³ хотын агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Зураг 54. Улаанбаатар³ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 12 харуулын дундаж, сараар, мг/м³



Хүснэгт 38. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 12-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	-	0.029	0.023	0.037	0.045	0.019	0.025	0.046	0.012	-	0.128	0.062
	Хамгийн их	-	0.062	0.056	0.077	0.076	0.067	0.046	0.076	0.021	-	0.224	0.096
	XXX*-с давсан хувь	-	10.0	6.0	16.0	29.0	4.0	-	33.0	-	-	94.0	71.0
	Хэмжилтийн тоо	-	31	31	31	31	23	28	9	17	-	18	31
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	0.129	0.053	0.096	0.060	0.056	0.041	0.071	0.025	0.066	0.060	0.058
	Хамгийн их	-	0.170	0.108	0.141	0.097	0.106	0.066	0.119	0.037	0.103	0.103	0.085
	XXX*-с давсан хувь	-	100.0	55.0	100.0	81.0	52.0	23.0	63.0	-	84.0	61.0	68.0
	Хэмжилтийн тоо	-	31	31	31	31	23	31	8	17	31	31	31
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	2.952	2.520	-	2.087	2.581	-	-	0.850	1.621	5.194	4.502	2.532
	Хамгийн их	5.563	5.900	-	6.088	6.925	-	-	1.954	3.345	12.637	13.643	5.806
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	4.0	4.0	-
	Хэмжилтийн тоо	21	93	-	93	93	-	-	9	51	93	93	93
Тоос PM ₁₀	Дундаж	0.118	0.214	0.328	0.196	0.308	-	0.273	0.116	0.157	0.269	0.189	0.166
	Хамгийн их	0.320	0.627	0.665	0.526	0.934	-	0.664	0.276	0.311	0.423	0.373	0.307
	XXX*-с давсан хувь	48.0	84.0	100.0	71.0	94.0	-	87.0	67.0	65.0	100.0	84.0	77.0
	Хэмжилтийн тоо	31	31	25	31	31	-	31	9	17	31	31	31
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.202	-	0.110	-	-	-	-	0.146	0.259	0.183	0.141
	Хамгийн их	-	0.569	-	0.257	-	-	-	-	0.302	0.413	0.367	0.284
	XXX*-с давсан хувь	-	93.0	-	77.0	-	-	-	-	100.0	100.0	100.0	97.0
	Хэмжилтийн тоо	-	28	-	31	-	-	-	-	17	31	31	31
Озон O ₃ **	Дундаж	0.012	-	-	0.010	0.004	-	-	0.026	0.017	0.012	-	0.027
	Хамгийн их	0.036	-	-	0.029	0.028	-	-	0.044	0.027	0.028	-	0.058
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	93	-	-	93	93	-	-	9	51	93	-	93

*- Хүлцэх хэм хэмжээ,

** - CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2017 оны 12-р сарын 06, 07-ны өдрүүдэд хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитридийн нэгдлийн хэмжээ хэвийн, хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж бохирдолтой, амоны азот 74.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 48.0 дахин, эрдэс фосфор 27.4 дахин хүлцэх хэм хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 39. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 12-р сард⁹

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	8.64	Хэвийн	1.12	Горим алдагдсан
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BХХ ₅	≤ 3	1.8	Хэвийн	144.0	48.0 дахин
Нитридийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.002	Хэвийн	0.012	Хэвийн
Амоны азот	NH ₄	≤0.5	0.05	Хэвийн	37.08	74.2 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.010	Хэвийн	2.738	27.4 дахин

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2017 онд байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 264 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 37.9 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 35.6 хувийг газрын зөрчил, 7.6 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 7.2 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 5.7 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 1.9 хувийг ойн зөрчил, 1.1 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 3.0 хувийг бусад зөрчил тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 64.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчлөөс 1.4 сая төгрөгийн нөхөн төлбөр төлөгджээ.

Хүснэгт 40. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2016			2017		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	166	182	79.2	387	264	64.4
Ой	16	10	3.8	8	5	2.2
Ан, амьтан	13	8	1.9	4	3	3.7
Газрын	14	44	38.2	199	94	44.0
Ус	7	-	1.1	1	-	-
Ургамал, хөрсний бохирдол	12	15	3.5	3	3	0.2
Агаар, химийн хорт бодис	12	21	5.0	14	15	1.2
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	20	19	6.6	102	100	8.4
Геодези зураг зүй, кадастр	13	29	1.5	9	20	3.4
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	7	1	7.7	35	19	1.1
Бусад	52	35	9.9	12	5	0.2


⁹ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори



ГЭМТ ХЭРЭГ

2017 онд 21947 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 4038 (18.4%) хэргээр бүрчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 28.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 32.7 пунктээр доогуур байна. Гэмт хэргийн улмаас 6093 хүн гэмтэж осолдон, 504 хүн нас барж, төр ард иргэдэд 166.8¹⁰ тэрбум төгрөгийн хохирол учруулсны 58.7 тэрбум (35.2%) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 55. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн 39.5 хувийг хулгайн, 24.6 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 12.1 хувийг залилан, 4.9 хувийг дээрмийн, 3.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг, 2.6 хувийг танхайн хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 41. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт	
	2015	2016	2017	Тоо	Хувь
Нийт	17 939	17 909	21 947	4 038	22.5
Үүнээс:					
Хүний амь	113	91	118	27	29.7
Хүчин	133	132	194	62	47.0
Дээрэм	446	404	1 081	677	167.6
Хулгай	5 899	6 098	8 667	2 569	42.1
Булаалт	183	158	46	-112	-70.9
Залилан	1 788	1 908	2 659	751	39.4
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	4 784	4 958	5 392	434	8.8
Хөдөлгөөний аюулгүй байдал	1 068	912	652	-263	-28.7
ашиглалтын журам зөрчих					
Бусдыг амиа хорлоход хүргэх	94	107	336	229	214.0
Ашиглах	201	193	221	28	14.5
Танхайрах	1 253	1 204	562	-642	-53.3
Бусад	1 977	1 741	2 019	278	16.0

⁷ Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 07-р сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн зарим заалт хүчингүй болсон тул 7 сараас буурсан.

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны XII сарын танилцуулга

2017 онд 37080 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оноос 11589 (23.8%) хүнээр буурсан байна.


Хүснэгт 42. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2016-2017	
	2015	2016	2017	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	17 939	17 909	21 947	4 038	22.5
Багануур	311	293	254	-39	-13.3
Багахангай	21	23	31	8	34.8
Баянгол	2 951	3 137	3 204	67	2.1
Баянзүрх	4 272	4 218	5 939	1 721	40.8
Налайх	423	489	393	-96	-19.6
Сонгинохайрхан	3 232	2 811	3 691	880	31.3
Сүхбаатар	3 085	2 962	3 816	854	28.8
Чингэлтэй	2 254	2 337	2 719	382	16.3
Хан-Уул	1 390	1 639	1 900	261	15.9

Хүснэгт 43. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Сэжигтнийг илрүүлж ял сонгосон	
Нийслэлийн дүн	18 297	5 272	28.8
Багануур	168	83	49.4
Багахангай	17	5	29.4
Баянгол	2 376	786	33.1
Баянзүрх	5 149	1 159	22.5
Налайх	272	106	39.0
Сонгинохайрхан	3 191	958	30.0
Сүхбаатар	3 444	975	28.3
Чингэлтэй	2 265	786	34.7
Хан-Уул	1 415	414	29.3

Зураг 56. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр



2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 13489 (61.5%) нь хөнгөн хэрэг, 5060 (23.0%) нь хүнд хэрэг, 3234 (14.7%) нь хүндэвтэр хэрэг, 164 (0.8%) нь онц хүнд хэрэг байна.

Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь хамгийн өндөр (49.4%) нь Багануур дүүрэгт байгаа бол, хамгийн бага (22.5%) нь Баянзүрх дүүрэгт байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 9618 болж, өмнөх оноос 4864 (33.6%) хүнээр буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1719 (17.9%) нь согтуугаар үйлдсэн, 1228 (12.8%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 251 (2.6%) нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 541 (5.6%) нь хүүхэд, 1564 (16.3%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 44. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2015	2016	2017	2015	2016	2017
Нийслэлийн дүн	5 899	6 098	8 867	5 049	5 319	7 506
Багануур	72	69	74	57	60	62
Багахангай	2	3	6	1	2	3
Баянгол	670	850	829	545	692	632
Баянзүрх	1 532	1 539	2 694	1 321	1 319	2 298
Налайх	97	154	127	82	142	111
Сонгинохайрхан	1 268	944	1 645	1 167	861	1 522
Сүхбаатар	1 171	1 170	1 479	912	973	1 240
Чингэлтэй	722	908	1 168	626	849	1 050
Хан-Уул	365	461	645	338	421	588



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2017 онд нийслэл хотын нутаг дэвсгэрт 271 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оноос 39.4 хувиар буурсан байна. Нийт гамшигт хүчтэй шороон шуурга 1, аадар бороо, үер 3, мал амьтны халдварт галзуу өвчин 4, үхрийн хорт салст хатуурал 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 251 осол бүртгэгдсэн байна.

Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 13 осол, бичил уурхай, нурангины 3 осол, усны 19 осол, барилгын 3 осол, бусад төрлийн 224 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 50 хүн амь насаа алдаж, 262 хүнийг аварч, гамшгийн үршгийг арилгах ажилд нийт 96.3 сая төгрөг зарцуулжээ.


Хүснэгт 45. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2012	2013	2014	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$ %
Нийслэлийн дүн	2 509	2 777	3 040	3 341	2 484	2 497	100.5
Багануур	29	30	37	51	41	32	78.0
Багахангай	4	3	6	11	8	3	37.5
Баянгол	353	445	452	451	411	363	88.3
Баянзүрх	589	629	728	792	606	596	98.3
Налайх	100	98	124	81	95	88	92.6
Сонгинохайрхан	457	537	591	737	540	555	102.7
Сүхбаатар	391	384	466	481	285	327	114.7
Хан-Уул	231	250	289	319	224	265	118.3
Чингэлтэй	355	401	347	418	274	268	97.8


Нийслэл хотод 2017 онд ахуйн 2479 гал түймэр гарч өмнөх оноос 0.5 хувиар өссөн байна. Гал түймрийн улмаас 25 хүн (үүнээс, хүүхэд 10) амь насаа алдаж, 25 хүн (үүнээс, хүүхэд 9) түлэгдэж гэмтсэн байна.

Гал түймрийн аюулаас 817 хүн, 960 байшин барилга, 3.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал, цахилгаанаас 209, санамсаргүй байдлаас 1600, санаатай үйлдлээр 2, шалтгаан тогтоогдоогүй 109, бусад шалтгаанаар 577 гал түймэр гарчээ.

Зураг 57. Гал түймэр, байршлаар



Зураг 58. Гал түймэр, шалтгаанаар



Гал түймэрт 823 гэр, орон сууц, 281 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 126 машин техник, малын 195 хашаа, саравч, бусад төрлийн 1054 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1478, төрийн өмчийн 698, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 303 объект өртөж, нийт 5.6 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2017 онд 241 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 276 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 12446 айл өрх, 9545 объектод үзлэг шалгалт хийж, 47523 галын зөрчил илрүүлж, 71 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 2543 заавал биелүүлэх албан шаардлага, 3312 мэдэгдэл хүргүүлж, 88.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР